СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Баруун урт сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СБА-2024/150-НА-СТА-ТШ3**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баруун-Урт сум<br>2024 он | Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга , тэргүүлэх аудитор: Г.Даваа<br>Утас: 70518396 Цахим хаяг: davaag@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Нарантуяа<br>Утас: 99029193 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn<br>Миндүг аудит ХХК-ийн захирал: С.Энхтөр<br>Утас: 95957791 Цахим хаяг: director@mindug.mn<br>Миндүг аудит ХХК-ийн менежер: Ц.Номингоо<br>Утас: 90098901 Цахим хаяг: coo@mindug.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 5

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 100

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 111


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2024.02.25 № 155

танай ________ -ны№ __________ -т

СҮХБААТАР АЙМГИЙН БАРУУН-УРТ СУМЫН НЭГДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Ж.ЧУЛУУНЦЭЦЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баруун-Урт сумын Нэгдүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баруун-Урт сумын Нэгдүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2023 онд мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,987.5 мянган төгрөг, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 991,661.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 902,480.2 мянган төгрөг буюу 90 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд төсөвт 5,034.8 мянган төгрөг төвлөрүүлж мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 90,134.4 мянган төгрөгийг тайланд толилуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудлыг тодорхойлоход материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн үнэлгээ өндөр, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын шийдвэр гаргасан

чухал асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал гараагүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулалд 10,136.4 мянган төгрөг, багш нарын гүйцэтгэлийн урамшуулалд 10,395.8 мянган төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.ДАВАА

D:/Bichig hereg/2024/A4 toot

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 83,771,688.18 | 181,822,389.15 |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 5,987,494.29 | 90,134,401.65 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 5,987,494.29 | 90,134,401.65 |
| **3121** | **Төгрөг** | 5,987,494.29 | 90,134,401.65 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 5,987,494.29 | 90,134,401.65 |
| **33** | **АВЛАГА** | 2,055,831.89 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 2,055,831.89 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 75,728,362.00 | 91,687,987.50 |
| **351** | **Түүхий эд материал** | 438,730.00 | 369,300.00 |
| 35130 | Эм боох материал | 438,730.00 | 369,300.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 75,289,632.00 | 91,318,687.50 |
| 35460 | Хүнсний материал | - | 2,659,433.50 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 75,289,632.00 | 88,659,254.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,337,515,097.61** | **2,305,272,947.77** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,337,515,097.61 | 2,305,272,947.77 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,256,875,097.61 | 2,224,932,947.77 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,222,207,318.00 | 2,222,207,318.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | - 61,857,819.59 | - 115,129,220.15 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 46,791,476.60 | 77,769,336.60 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | - 15,650,511.26 | - 28,015,726.80 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 68,799,425.53 | 68,799,425.53 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | - 13,390,786.87 | - 21,398,719.35 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 13,340,000.00 | 28,588,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | - 5,788,683.80 | - 10,312,145.06 |
| 39217 | Ном | 2,424,679.00 | 2,424,679.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 80,640,000.00 | 80,340,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - 200,000.00 | - 500,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 79,340,000.00 | 79,340,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,421,286,785.79** | **2,487,095,336.92** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **9,801,024.00** | **7,773,593.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 9,801,024.00 | 7,773,593.00 |
| **413** | **Өглөг** | 9,801,024.00 | 7,773,593.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 7,701,024.00 | 5,113,320.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 2,100,000.00 | 2,660,273.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 2,100,000.00 | 2,660,273.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,411,485,761.79** | **2,479,321,743.92** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,411,485,761.79 | 2,479,321,743.92 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 70,051,902.66 | 70,051,902.66 |
| 51101 | Өмч: - төрийн | 70,051,902.66 | 70,051,902.66 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,231,637,819.16 | 2,299,473,801.29 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 116,454,377.48 | 2,231,637,819.16 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 2,115,183,441.68 | 67,835,982.13 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 109,796,039.97 | 109,796,039.97 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,421,286,785.79** | **2,487,095,336.92** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,875,242,022.30** | **1,033,740,882.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,136,613,127.60** | **42,078,982.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,136,613,127.60 | 42,078,982.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,136,613,127.60 | 42,078,982.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 2,136,613,127.60 | 42,078,982.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **738,628,894.70** | **991,661,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 586,877,200.00 | 867,103,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 586,877,200.00 | 867,103,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 16,000,000.00 | 1,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 16,000,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 1,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 135,751,694.70 | 123,558,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 135,751,694.70 | 123,558,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **759,577,580.62** | **965,904,899.87** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **759,577,580.62** | **965,904,899.87** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 748,703,780.62 | 950,733,665.49 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 428,612,451.22 | 549,707,235.73 |
| 210101 | Үндсэн цалин | 314,219,299.67 | 397,595,584.78 |
| 210102 | Нэмэгдэл | 90,471,579.45 | 132,426,309.69 |
| 210104 | Урамшуулал | 23,921,572.10 | 19,685,341.26 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 52,872,433.58 | 69,151,447.30 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,974,708.95 | 47,484,234.73 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,232,301.02 | 5,586,380.54 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,385,840.85 | 4,473,880.81 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 832,050.55 | 1,055,177.29 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,447,532.21 | 10,551,773.93 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 106,103,119.00 | 101,915,541.62 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,689,045.00 | 11,619,012.99 |
| 210302 | Түлш, халаалт | 81,058,560.00 | 76,054,098.76 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 16,355,514.00 | 14,242,429.87 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,287,200.00 | - |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 2,287,200.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 92,613,347.00 | 120,924,931.00 |
| 210502 | Хоол, хүнс | 92,613,347.00 | 120,924,931.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,764,694.00 | 7,206,750.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,764,694.00 | 7,206,750.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,110,000.00 | 1,559,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,110,000.00 | 1,559,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 60,340,535.82 | 100,268,359.84 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,909,745.00 | 18,416,990.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,093,555.00 | 3,383,360.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 39,337,235.82 | 78,468,009.84 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 10,873,800.00 | 15,171,234.38 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 10,873,800.00 | 10,136,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,873,800.00 | 10,136,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 5,034,834.38 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 5,034,834.38 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **2,115,664,441.68** | **67,835,982.13** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 481,000.00 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 481,000.00 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - 481,000.00 | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **2,115,183,441.68** | **67,835,982.13** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **738,628,894.70** | **991,661,900.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **738,628,894.70** | **991,661,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 586,877,200.00 | 867,103,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 586,877,200.00 | 867,103,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 16,000,000.00 | 1,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 16,000,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 1,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 135,751,694.70 | 123,558,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 135,751,694.70 | 123,558,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **722,877,400.41** | **897,266,992.64** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **722,877,400.41** | **897,266,992.64** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **712,003,600.41** | **882,095,758.26** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 428,731,319.83 | 547,620,433.39 |
| 210101 | Үндсэн цалин | 314,320,712.28 | 374,447,617.70 |
| 210102 | Нэмэгдэл | 90,489,035.45 | 153,673,731.96 |
| 210104 | Урамшуулал | 23,921,572.10 | 19,499,083.73 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 52,872,433.58 | 69,182,417.75 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,974,708.95 | 47,505,294.63 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,232,301.02 | 5,588,858.18 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,385,840.85 | 4,475,862.92 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 832,050.55 | 1,055,672.82 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,447,532.21 | 10,556,729.20 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 101,271,600.00 | 106,523,765.62 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,689,045.00 | 11,619,012.99 |
| 210302 | Түлш, халаалт | 81,058,560.00 | 76,054,098.76 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,523,995.00 | 18,850,653.87 |
| **2105** | **Нормативт зардал** | 92,613,547.00 | 123,837,141.50 |
| 210502 | Хоол, хүнс | 92,613,547.00 | 123,837,141.50 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,000,000.00 | 7,600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.00 | 7,600,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,110,000.00 | 1,559,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,110,000.00 | 1,559,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 30,404,700.00 | 25,772,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,054,700.00 | 21,094,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,350,000.00 | 4,678,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **10,873,800.00** | **15,171,234.38** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 10,873,800.00 | 10,136,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,873,800.00 | 10,136,400.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 5,034,834.38 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 5,034,834.38 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **15,751,494.29** | **94,394,907.36** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **9,764,000.00** | **10,248,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **9,764,000.00** | **10,248,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 9,764,000.00 | 10,248,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 9,764,000.00 | 10,248,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **- 9,764,000.00** | **- 10,248,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 5,987,494.29 | 84,146,907.36 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 5,987,494.29 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 5,987,494.29 | 90,134,401.65 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 70,051,902.66 | 109,796,039.97 | 116,454,377.48 | 296,302,320.11 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **70,051,902.66** | **109,796,039.97** | **116,454,377.48** | **296,302,320.11** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 2,115,183,441.68 | 2,115,183,441.68 |
| C08 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **70,051,902.66** | **109,796,039.97** | **2,231,637,819.16** | 2,411,485,761.79 |
| D01 | **2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **70,051,902.66** | **109,796,039.97** | **2,231,637,819.16** | **2,411,485,761.79** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **70,051,902.66** | **109,796,039.97** | **2,231,637,819.16** | **2,411,485,761.79** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 67,835,982.13 | 67,835,982.13 |
| D09 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **70,051,902.66** | **109,796,039.97** | **2,299,473,801.29** | **2,479,321,743.92** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 997,649,300.00 | 902,480,158.26 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 997,649,300.00 | 902,480,158.26 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 987,512,900.00 | 892,343,758.26 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 626,811,200.00 | 547,620,433.39 |
| 210101 | Үндсэн цалин | 419,635,900.00 | 374,447,617.70 |
| 210102 | Нэмэгдэл | 187,528,400.00 | 153,673,731.96 |
| 210104 | Урамшуулал | 19,646,900.00 | 19,499,083.73 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 78,350,800.00 | 69,182,417.75 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53,278,500.00 | 47,505,294.63 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,268,100.00 | 5,588,858.18 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,014,400.00 | 4,475,862.92 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,253,700.00 | 1,055,672.82 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,536,100.00 | 10,556,729.20 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 111,558,600.00 | 106,523,765.62 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,200,000.00 | 11,619,012.99 |
| 210302 | Түлш, халаалт | 77,358,600.00 | 76,054,098.76 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 23,000,000.00 | 18,850,653.87 |
| **2105** | **Нормативт зардал** | 125,469,100.00 | 123,837,141.50 |
| 210502 | Хоол, хүнс | 125,469,100.00 | 123,837,141.50 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,000,000.00 | 12,000,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,400,000.00 | 4,400,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,600,000.00 | 7,600,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,559,400.00 | 1,559,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,559,400.00 | 1,559,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 31,763,800.00 | 31,620,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,085,500.00 | 26,942,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,678,300.00 | 4,678,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 10,136,400.00 | 10,136,400.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 10,136,400.00 | 10,136,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,136,400.00 | 10,136,400.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 990,661,900.00 | 990,661,900.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 990,661,900.00 | 990,661,900.00 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 990,661,900.00 | 990,661,900.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 5,987,494.29 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 95,169,236.03 |

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 5,834.9 мянган төгрөгийн 3 зөрчил[1] илэрснээс, 1 албан шаардлага хүргүүлж, 5,834.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өгөх саналтай байна.

**3.1 Албан шаардлага**

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэр, орлого зарлагын 163 мэдээллээс хуулийн хугацаанд 161 мэдээлэл бүрэн байршуулсан бөгөөд 2 мэдээлэл хоцроосон. Өмнөх оны аудитын зөвлөмжөөр өгсөн алдааг дахин давтсан.

Шилэн дансны мэдээллүүдийг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан цаг хугацаанд тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

**3.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт</u>:* Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 12 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*: Үндсэн хөрөнгийн эдийн засгийн насжилт буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана" заалтыг мөрдөж, Орон нутгийн өмчийн албанд хүргүүлэн, шийдвэрлүүлж ажиллах;

2. Цалингийн өглөгийн бүртгэлтэй холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт</u>:* Цалингийн зардлыг Нийгмийн даатгалын тайлан, цалингаас суутган тооцсон ХХОАТ-ын тайлангуудад дутуу тусгаж тайлагнасан.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*: Нягтлан бодох бүртгэлийн 9.6 ‘’Харилцагч санхүүгийн байгууллагын баталгаажуулсан цахим санхүүгийн тайланд үндэслэн холбогдох байгууллага татвар, шимтгэл, хураамжийн тооцоо хийнэ’’ зүйл заалтыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Цалингийн зардлыг НД,ХХОАТ-ын тайланд дутуу тусгасан, ХХОАТ өглөг дутуу суутгасан | 1 | 5,834.9 | 1 | 5,834.9 | | | 1 | 5,834.9 |
| Шилэн дансны 2 мэдээлэл хоцроосон | 1 | | 1 | | | | 1 | |
| Анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг стандартын дагуу бүртгээгүй | 1 | | 1 | | | | 1 | |
| Дүн | 3 | 5,834.9 | 3 | 5,834.9 | | | 3 | 5,834.9 |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалт-ны тоо | Тоо | Дүн |
| Цалингийн зардлыг НД,ХХОАТ-ын тайланд дутуу тусгасан, ХХОАТ өглөг дутуу суутгасан | 1 | 5,834.9 | | | | | 1 | 5,834.9 | | | | |
| Анхны өртгөө нөхсөн 43 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлд байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Дүн | 2 | 5,834.9 | | | | | 1 | 5,834.9 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | |
| Шилэн дансны 2 мэдээлэл хоцроосон | 1 | - | 1 | | | |
| Дүн | 1 | | 1 | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | |
| | | | | | | |
| Дүн | | | | | | |
| Нийт дүн | 1 | | 1 | | | |